



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/100/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
.....	5
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын ТАЙЛАН	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.3 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/107
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
С.БЯМБАА ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аргалант сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Аргалант сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 110,031.0 мянган төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайланд өргөн тархсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

19020358

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,213,780.73	72,697,856.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	11,701,817.33
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	11,701,817.33
31210	Төгрөг	0.00	11,701,817.33
31211	Төрийн сангийн харилцах	0.00	11,612,123.28
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	89,694.05
33	АВЛАГА	0.00	4,857,179.00
33500	Бусад авлага	0.00	4,857,179.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	4,857,179.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,213,780.73	56,138,859.73
35100	Түүхий эд материал	9,515,200.71	24,532,568.72
35130	Эм боох материал	9,515,200.71	24,532,568.72
35400	Хангамжийн материал	20,698,580.02	31,606,291.01
35410	Бичиг хэргийн материал	88,600.00	0.00
35420	Аж ахуйн материал	11,550,241.32	11,740,541.32
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	4,840,000.00
35450	Барилгын засварын материал	0.00	2,800,000.00
35460	Хүнсний материал	839,511.20	1,418,662.19
35470	Бусад хангамжийн материал	8,220,227.50	10,807,087.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	373,608,644.89	411,837,674.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	373,608,644.89	411,837,674.53
39200	Биет хөрөнгө	366,008,644.89	404,444,073.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	315,485,319.00	315,485,319.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(25,001,951.04)	(39,361,250.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,500,000.00	129,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(46,987,999.69)	(55,666,999.60)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	71,210,095.32	93,396,052.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(42,291,233.65)	(49,881,828.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,413,684.90	18,728,684.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,123,025.95)	(8,799,059.67)
39217	Ном	803,756.00	836,756.00
39300	Биет бус хөрөнгө	7,600,000.00	7,600,000.00
39301	Програм хангамж	540,000.00	540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(540,000.00)	(540,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,600,000.00	7,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	403,822,425.62	484,535,530.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	2,904,901.64
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	2,904,901.64
41300	Өглөг	0.00	2,904,901.64
41360	Бусад өглөг	0.00	2,904,901.64
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	2,904,901.64
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	403,822,425.62	481,630,628.95
51	Засгийн газрын хувь оролцоо	403,822,425.62	481,630,628.95
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	153,123,971.47	153,123,971.47
51200	Хуримтлагдсан үр дүн	2,269,321.94	80,077,525.27

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	432,202.51	2,269,321.94
51220	Тайлант үеийн үр дүн	1,837,119.43	77,808,203.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	248,429,132.21	248,429,132.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	403,822,425.62	484,535,530.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	358,047,762.53	536,406,164.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,008,802.53	104,255,499.44
120	Нийтлэг татварын бус орлого	44,008,802.53	104,255,499.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	607,441.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	607,441.48
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	32,530,370.00	69,475,957.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	11,478,432.53	34,172,100.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	314,038,960.00	432,150,665.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	265,828,900.00	302,634,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	265,828,900.00	302,634,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,692,442.00	89,912,355.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,692,442.00	89,912,355.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,623,500.00	29,102,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,623,500.00	29,102,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,894,118.00	10,501,510.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,894,118.00	10,501,510.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	356,210,643.10	458,597,961.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	356,210,643.10	457,332,761.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,157,752.52	455,613,236.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,387,511.39	224,812,514.83
210101	Үндсэн цалин	138,166,394.05	162,946,633.83
210102	Нэмэгдэл	51,993,334.40	42,388,494.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,498,000.00	3,538,619.02
210104	Урамшуулал	13,729,782.94	15,938,767.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,151,851.23	29,927,245.71
210201	Тэтгэврийн даатгал	18,005,520.88	21,202,644.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,074,213.66	2,181,987.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,644,135.43	1,801,145.71
210204	Ажилгүйдлийн даатгал	402,216.84	388,346.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,025,764.42	4,353,121.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,710,480.00	27,431,125.43
210301	Гэрэл, цахилгаан	3,475,980.00	5,286,175.43

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	21,000,000.00	22,029,450.00
210303	Цэвэр, бохир ус	234,500.00	115,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,733,774.97	16,660,813.30
210401	Бичиг хэрэг	1,859,150.00	766,600.00
210402	Тээвэр, шатахуун	10,819,985.00	14,147,113.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,014,350.00	851,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,040,289.97	730,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	165,000.00
2105	Нормативт зардал	23,999,450.01	42,116,970.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,017,175.09	33,427,717.39
210502	Хоол, хүнс	3,982,274.92	8,689,253.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	623,000.00	1,162,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	242,000.00
210604	Урсгал засвар	623,000.00	920,000.00
2107	Томилолт, зочны зардал	496,000.00	342,000.00
210702	Дотоод албан томилолт	496,000.00	342,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	561,350.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	237,350.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,494,334.92	113,160,566.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,608,600.00	80,855,638.95
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,885,734.92	32,304,927.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,052,890.58	1,719,524.57
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,146,220.00	1,719,524.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,146,220.00	1,719,524.57
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,906,670.58	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,906,670.58	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1,265,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1,265,200.00
221001	Их засвар	0.00	1,265,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,837,119.43	77,808,203.33
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,837,119.43	77,808,203.33

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	153,123,971.47	248,429,132.21	432,202.51	401,985,306.19
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	153,123,971.47	248,429,132.21	432,202.51	401,985,306.19
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,837,119.43	1,837,119.43
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	153,123,971.47	248,429,132.21	2,269,321.94	403,822,425.62
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	153,123,971.47	248,429,132.21	2,269,321.94	403,822,425.62
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	153,123,971.47	248,429,132.21	2,269,321.94	403,822,425.62
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	77,808,203.33	77,808,203.33
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	153,123,971.47	248,429,132.21	80,077,525.27	481,630,628.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	314,038,960.00	432,758,106.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	607,441.48
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	607,441.48
120009	Бусад орлого	0.00	607,441.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	314,038,960.00	432,150,665.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	265,828,900.00	302,634,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	265,828,900.00	302,634,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,692,442.00	89,912,355.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,692,442.00	89,912,355.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,623,500.00	29,102,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,623,500.00	29,102,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,894,118.00	10,501,510.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,894,118.00	10,501,510.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	310,025,560.00	419,998,289.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,025,560.00	419,998,289.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	297,972,669.42	418,278,764.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,387,511.39	224,812,514.83
210101	Үндсэн цалин	138,166,394.05	162,946,633.83
210102	Нэмэгдэл	51,993,334.40	42,388,494.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,498,000.00	3,538,619.02
210104	Урамшуулал	13,729,782.94	15,938,767.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,151,851.23	29,110,404.07
210201	Тэтгэврийн даатгал	18,005,520.88	20,507,810.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,074,213.66	2,159,979.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,644,135.43	1,706,865.55
210204	Ажилгүйдлийн даатгал	402,216.84	388,346.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,025,764.42	4,347,401.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,710,480.00	26,520,675.43
210301	Гэрэл, цахилгаан	3,475,980.00	5,286,175.43
210302	Түлш, халаалт	21,000,000.00	21,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	234,500.00	234,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,814,635.00	18,478,233.30
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	935,300.00
210402	Тээвэр, шатахуун	10,814,785.00	15,176,563.30

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,499,850.00	871,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,494,970.00
2105	Нормативт зардал	13,400,341.80	17,784,349.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,351,941.80	12,246,525.00
210502	Хоол, хүнс	4,048,400.00	5,537,824.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,129,800.00	5,302,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	563,000.00	642,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,800,000.00	3,798,500.00
210604	Урсгал засвар	766,800.00	862,200.00
2107	Томилолт, зочны зардал	496,000.00	342,000.00
210702	Дотоод албан томилолт	496,000.00	342,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,561,350.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	237,350.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,320,700.00	95,927,687.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,320,700.00	95,927,687.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,052,890.58	1,719,524.57
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,146,220.00	1,719,524.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,146,220.00	1,719,524.57
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,906,670.58	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,906,670.58	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,013,400.00	12,759,817.33
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,013,400.00	1,058,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,013,400.00	1,058,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,013,400.00	1,058,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,013,400.00	1,058,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,013,400.00)	(1,058,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	11,701,817.33
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	11,701,817.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	348,551,200.00	329,514,103.63	19,037,096.37	94.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,551,200.00	329,514,103.63	19,037,096.37	94.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348,551,200.00	329,514,103.63	19,037,096.37	94.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234,420,400.00	224,812,514.83	9,607,885.17	95.9
210101	Үндсэн цалин	163,038,600.00	162,946,633.83	91,966.17	99.9
210102	Нэмэгдэл	42,390,000.00	42,388,494.84	1,505.16	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	3,538,619.02	997,380.98	78.0
210104	Урамшуулал	24,455,800.00	15,938,767.14	8,517,032.86	65.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,646,800.00	29,110,404.07	2,536,395.93	92.0
210201	Тэтгэврийн даатгал	22,270,100.00	20,507,810.88	1,762,289.12	92.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,344,200.00	2,159,979.04	184,220.96	92.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,875,300.00	1,706,865.55	168,434.45	91.0
210204	Ажилгүйдлийн даатгал	468,800.00	388,346.96	80,453.04	82.8
210205	Эрүүл мэндийн даатгал	4,688,400.00	4,347,401.64	340,998.36	92.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,952,300.00	26,520,675.43	1,431,624.57	94.9
210301	Гэрэл, цахилгаан	6,715,300.00	5,286,175.43	1,429,124.57	78.7
210302	Түлш, халаалт	21,000,000.00	21,000,000.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	237,000.00	234,500.00	2,500.00	98.9
2104	Хангамж, бараа материалын зардал	19,195,000.00	18,511,233.30	683,766.70	96.4
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	968,300.00	31,700.00	96.8
210402	Тээвэр, шатахуун	15,195,000.00	15,176,563.30	18,436.70	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	871,400.00	628,600.00	58.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,494,970.00	5,030.00	99.7
2105	Нормативт зардал	20,986,700.00	17,784,349.00	3,202,351.00	84.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,486,700.00	12,246,525.00	240,175.00	98.1
210502	Хоол, хүнс	8,500,000.00	5,537,824.00	2,962,176.00	65.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,950,000.00	6,643,050.00	306,950.00	95.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	1,982,350.00	17,650.00	99.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,800,000.00	3,798,500.00	1,500.00	100.0
210604	Урсгал засвар	1,150,000.00	862,200.00	287,800.00	75.0
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	342,000.00	1,158,000.00	22.8
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	342,000.00	1,158,000.00	22.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,900,000.00	5,789,877.00	110,123.00	98.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,900,000.00	5,789,877.00	110,123.00	98.1

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	348,551,200.00	342,238,310.00	6,312,890.00	98.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	302,634,400.00	331,736,800.00	(29,102,400.00)	109.6
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	302,634,400.00	302,634,400.00	0.00	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,102,300.00	0.00	29,102,300.00	0.0
320001	Орон нутгийн төсвөөс	29,102,300.00	0.00	29,102,300.00	0.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,814,500.00	10,501,510.00	6,312,990.00	62.5
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,814,500.00	10,501,510.00	6,312,990.00	62.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		89,822,660.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ		89,822,660.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		89,822,660.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		89,822,660.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		89,822,660.95
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		89,912,355.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		89,912,355.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		89,912,355.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		89,694.05
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		89,694.05

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 26-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-ийн 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.4 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль,
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд өргөдлийн дагуу хяналт шалгалт хийгдэж, 10,238.6 мянган 2 төлбөрийн акт тогтоосон байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 356,210.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,562.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,493.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Архуст сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль,

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд Тусгай зориулалтын шилжүүлгээс 302,634.4 мянга, орон нутгийн төсвөөс 29,102.4 мянган төгрөгийн санхүүжилтийг 100.0 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 89,912.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 421,056.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр 1,058.0 мянган төгрөгийн, хандиваар 69,475.9 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 34,172.1 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 96,932.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 105,179.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 4,857.2 мянган төгрөгийн авлагатай, 2,904.9 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 11,701.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 56,138.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 412,044.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	11,701.8	11,701.8
Авлага	0.0	4,857.2	4,857.2
Бараа материал	30,213.8	56,138.9	25,925.1
Үндсэн хөрөнгө	373,608.6	411,837.7	38,229.1
Нийт хөрөнгө	403,822.4	484,535.5	80,713.1
Нийт өр төлбөр	0.00	2,904.9	2,904.9
Засгийн газрын хувь оролцоо	403,822.4	481,630.6	77,808.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	403,822.4	484,535.5	80,713.1

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 11,701.8 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 11,701.8 мянган төгрөгөөр өссөн байна.
- Авлага дансны үлдэгдэл 4,857.2 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 4,857.2 мянган төгрөгөөр өссөн байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 56,138.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 25,925.1 мянган төгрөгөөр өссөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 412,044.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 38,435.4 мянган төгрөгөөр өссөн нь 70,534.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 32,098.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 481,837.0 мянган төгрөг болж, 78,014.6 9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 348,551.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсөвт тодотгол хийгдээгүй.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тусгай зориулалтын шилжүүлгээс 302,634.4 мянга, ЭМДС-гаас 10,501.5 мянга, орон нутгийн төсвөөс 29,102.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 329,514.1 мянган төгрөгийг зарцуулж, 1,719.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 11,612.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 329,514.1 мянган төгрөг буюу 94.5 байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 89,912.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 89,822.3 мянган төгрөгийг зарцуулж, 89.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр 1,058.0 мянган төгрөгийн, хандиваар 69,475.9 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь жилийн эцсээр солигдсон, нэг хэсэг нягтлан бодогчгүй байсан зэргээс завсрын аудит хийлгээгүй. Дарга нь мөн 3 удаа солигдсон ба сүүлийн 2 дарга нь түр орлон гүйцэтгэгч байна.

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангууд уялдаагүй, ЭМДЕГ-тай тооцоо нийлсэн актаарх авлага, бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөгийн дүн санхүүгийн тайлангийн дүнтэй тохирохгүй байна. Сангийн яамны И-тайланд шивэгдсэн болон аудитад ирүүлсэн санхүүгийн тайлан алдаатай байна.

Батлагдсан төсвийн дүн тодорхойгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлээгүй, бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн, харилцагчидтай тооцоо нийлсэн болон хөрөнгийн тооллогын баримт хангалтгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 112 мэдээллийг хугацаандаа, 16 мэдээллийг байршуулаагүй, 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийлгээгүй.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

2021 оны аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 110,031.0 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 110,031.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 10 зөвлөмж өглөө.

4.1 Залруулга

Залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, зарлага, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зөв тусгаагүйгээс уг тайлан илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу үнэн зөв бэлтгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2.Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/”, 54.5.2-т “татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт”, 54.5.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл”, 54.5.4-т “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/”, 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-д заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлж байх

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 120 нэр төрлийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна. байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын баримт бүрэн бус байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Тооллогыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

5. Бараа материалын данстай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 47 нэрийн үндсэн хөрөнгө бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох

бүртгэлийн дансны заавар"-ын 4.15-д "Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно", Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 4.7-д "Нэг жил хүртэл хугацаанд ашиглагдах хөрөнгийг эргэлтийн хөрөнгө түүнээс дээш хугацаанд ашиглагдах хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгө гэнэ", 4.8-д "Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө: б. Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм." гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт", "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон заавруудыг мөрдөн дансны ангилал зөв хийх, холбогдох зөвшөөрлийг авч шийдвэрлүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

6.Өглөг, авлагын тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт:

Харилцахын үлдэгдэл, 6-гаас бусад харилцагчидтай авлага, өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт", "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж:

Харилцагчидтай авлага, өр төлбөрийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

7.Өглөг, авлагын тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой асуудал

7.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд дээрх 6 харилцагчийн авлага, өглөгийн үлдэгдлийг зөрүүтэй тусгасан, тухайлбал авлагыг 2,575.3 мянган төгрөгөөр дутуу, өглөгийг 1,614.3 мянган төгрөгөөр илүү тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт", "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7.2 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв бэлтгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

8. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

8.1 Илрүүлэлт:

120017-Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө дансанд 69,476.0 мянга, 120018- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- бараа материал дансанд 34,172.1 мянган төгрөгийг бүртгэхийг 11200045 -Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт", "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8.2 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу үнэн зөв бэлтгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

9. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

9.1 Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд эх үүсвэрээс төвлөрүүлэх шилжүүлэг 1,719.5 мянган төгрөгийг тохируулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт", "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

9.2 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу үнэн зөв бэлтгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

10. Шилэн данстай холбоотой асуудал

10.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

10.2 Өгсөн зөвлөмж:

Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд, үнэ зөв, бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Аргалант сумын Эрүүл мэндийн төв	10	110,031.0							10	110,031.0
	ДҮН	10	110,031.0							10	110,031.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn